



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/172

Чингис хот

Коронавируст халдвар /Ковид19/-ын эсрэг
вакцинаар дархлаажуулах үйл ажиллагааг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас халгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 05 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/183 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг вакцинаар зорилтот бүлгийн хүн амыг дархлаажуулах арга хэмжээг 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахыг бүх шатны Засаг дарга, Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг вакцинжуулалт хийх дархлаажуулалтын цэгийн бэлэн байдлыг ханган, дархлаажуулалтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Л.Мэндбаяр/-д үүрэг болгосугай.

3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг вакцины хадгалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдалд хяналт тавьж хамтран ажиллахыг Цагдаагийн газрын дарга /Б.Батсайхан/, дархлаажуулалт зохион байгуулах хугацаанд цахилгаан эрчим хүчний тасралтгүй байдлыг хангаж ажиллахыг Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн харьяа Хэнтий Цахилгаан түгээх сүлжээ салбарын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Ариунаа/ нарт даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011410